

Түүх 9 : Алдагдсан хонь

Библийн эшлэл
[Лук 15:7]

Би та нарт хэлье. Мөн үүний адил, гэмших шаардлагагүй ерөн есөн зөвт хүнээс илүүгээр гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.

Хүмүүс Есүсийн үгийг сонсохыг их хүсэмжилдэг байв.

Тиймээс ч Есүсийн явсан газар бүрт олон хүмүүс цуглардаг байлаа.

Гэвч Есүсийг нүгэлтнүүдтэй хамт байдгаас нь болж Түүнд дургүйлхдэг хүмүүс ч олон байв.

Тийм болхоор Есүс тэдэнд зориулж нэгэн сургаалт зүйрлэлийг ярьж өгөв.

Эрт дээр үед нэг хоньчин зуун хоньтой байжээ.

Энэ хоньчин хонио хайрлаж, асарч халамжилдаг байв.

Бэлчээрээсээ гэртээ харих цаг болоход хоньчин хонио тоолж гэнэ.

Тэрээр хонио дахин дахин тоолсон ч ерөн есөн хонь байв.

Хоньчин алга болсон нэг хониңдоо маш ихээр санаа зовж энэ тэрүүгээр явж хайсаар байв.

Нэг мэдэхэд гадаа тас харанхуй болсон байв.

Харин хоньчин хонио хайсаар явахдаа усанд унаж, бүдэрч, хүндхэн замыг түүлж байсан ч шантралгүйгээр үргэлжлүүлэн хонио хайсаар байв.

Гэтэл яг тэр үед!! Намуухан чимээ дуулдав.

Хоньчин чимээ гарсан зүг рүү хамаг хурдаараа гүйв.

Чимээ гарсан зүгт яваад очтол алдагдсан хонь хадны эрмэгт зүүгдэн, бүх бие нь норж, даарч хөрсөн, айж чичирсэн байж байв.

Хоньчин хонио авраад, мөрөндөө мөрлөн гэрлүүгээ баяртайгаар буцав.



Хоньчин гэртээ хүрч ирээд чанга дуугаар хайрт эхнэр болон хүүхдүүдээ ингэж хэлэв.

“Би олчихлоо, алдагдсан хонио олчихлоо!!! Ойр хавийн хүмүүсийг бүгдийг нь дуудаж найр хийнэ ээ”

Есүс хүмүүст ингэж айлдав.

“Та нар ч мөн адил нэг хонио алдчихаад хайж олвол баярлахгүй гэж үү?

Бурхан ч бас нэг хүн гэмшээд Бурхан руу эргэж ирвэл үнэхээр их баярлах болно.

Бурхан хэнийг ч алдахыг хүсдэггүй.” гэв.

Есүс хоньчин болон хонины талаарх бас нэгэн өөр сургаалт зүйрлэлийг ярьж өгөв.

“Сайн хоньчин бол хонио мэддэг.

Хонь ч хоньчныхоо дууг таниж, Түүнийг дагадаг.


Харин хонь нь танихгүй хүн хараад зугтдаг бол сайн хоньчин хэзээ ч зугтдаггүй бөгөөд араатан амьтан хоньдийг нь барихаар ирвэл араатан амьтадтай тулалддаг.

Сайн хоньчин бол хонио ямагт хамгаалдаг билээ.”

Есүс Өөрийнхөө хоньдийг хамгаалахын тулд Өөрийн амиа өгөх талаар айлдсан юм.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултанд хариулахын тулд онцгой тэмдэгтийн оронд байгаа үсэгийг цуглуулж үг болгоорой.




а. Хоньчин хэдэн хоньтой байсан бэ? ★-<-< _____

б. Зуун хониноос нэг хонинд юу тохиолдсон бэ? ☼-≠-↓-☼-⊗-↓-€-☼-■ _____

в. Лук 15:7 эшлэлийг уншаад хариулаарай. Нүгэлтэй нэг хүн явал тэнгэрт их баяр хөөр болдог гэсэн вэ?

⊗-Г-⇐-☼-OI-¥ _____

Доорх зурган дээрх хонины дүрсийг хэлбэрээр нь хайчлаарай. Хонин дээрх дугуй дүрсүүдийг хайчлаарай. Хонин дээр нь хөвөн наагаарай. Ингээд хурууны хүүхэлдэйг бүтээгээрэй.



- Дараах эшлэлийг уншаад цээжлээрэй. (Лук 15:7)

Би та нарт хэлье. Мөн үүний адил, гэмших шаардлагагүй ерөн есөн зөвт хүнээс илүүгээр гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.

